СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: СҮХБААТАР СУМЫН “ЦАГААН-ЭРЭГ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДОТООД АУДИТ

Аудитын код: ДА-2026/17/ҮА

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн товьёг	**2**
Хавсралт	**2**
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	**3**
1. Ерөнхий мэдээлэл	**4**
2. Аудитын үр дүн	**6**
3. Аудитаар илрүүлсэн асуудал	**9**
4. Илрүүлсэн зөрчил	**16**
5. Дүгнэлт	**17**
6. Зөвлөмж	**19**

Товчилсон үгийн жагсаалт

Товчлол	*Тайлбар*
ДАДС	*Дотоод аудитын Дэлхийн Стандарт (Дотоод аудиторуудын институт, 2024)*
ОНӨААТҮГ	*Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар*
ААТҮГ	*Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар*
ЗДТГ	*Засаг даргын Тамгын газар*
СХДАГ	*Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар*
ИТХ	*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал*
ТБОНӨТХ	*Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль*
ТОНӨХБАҮХАТХ	*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль*
НББ	*Нягтлан бодох бүртгэл*
ХДЖ	*Хөдөлмөрийн дотоод журам*
НӨАТ	*Нэмэгдсэн өртгийн албан татвар*
НДШ	*Нийгмийн даатгалын шимтгэл*

Хүснэгтийн товьёг

д/д	***Тайлбар***	***Хуудасны дугаар***
Хүснэгт 1	*Аудитын ажлын эрсдэлийн үнэлгээ ба үр дүн*	*5*
Хүснэгт 2	*2026 оны төсвийн бүтэц*	*6*
Хүснэгт 3	*Төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл*	*6*
Хүснэгт 4	*2026 оны тендер шалгаруулалт ба төлбөрийн гүйцэтгэл*	*7*
Хүснэгт 4а	*2025 оны цалин хөлсний сарын гүйцэтгэл*	*8*
Хүснэгт 4б	*2025, 2026 оны 1–9 дүгээр сарын цалин хөлсний харьцуулалт*	*8*
Хүснэгт 5	*Ноцтой байдлын үнэлгээний матриц*	*9*
Хүснэгт 6	*Ноцтой байдлаар эрэмбэлсэн илрүүлэлтүүд*	*9*
Хүснэгт 7	*Илрүүлсэн зөрчил, шийдвэрлэлтийн нэгтгэл*	*17*
Хүснэгт 8	*Засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үр нөлөөний үнэлгээ*	*18*
Хүснэгт 9	*Аудитын ажлын ерөнхий дүгнэлт*	*18*
Хүснэгт 10	*Илрүүлэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө*	*21*

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ДА-2026/17/ҮА дугаар удирдамжийг тус тус үндэслэн дотоод аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт:	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ (цаашид “ААТҮГ” гэх)-ын санхүү, үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, цалин хөлс, хөрөнгийн зарцуулалт нь хууль тогтоомж, дүрэм журам, эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцэж байгаа эсэхийг магадлах, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг үнэлж, эрсдэлийг бууруулах зөвлөмж өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.
Аудитын хамарсан хүрээ:	Аймгийн Засаг даргын баталсан ДА-2026/17/ҮА дугаар удирдамжийн дагуу ААТҮГ-ын 2025 он, 2026 оны 1–9 дүгээр сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа: 2026 оны 1–9 дүгээр сарын харилцах дансны гүйлгээ, төсвийн санхүүжилт, худалдан авах ажиллагаа, анхан шатны баримт, ил тод байдал; 2025 оны 1–12 дугаар сарын цалин хөлс (цалин бодолтын тайлан), 2025 онд гаргасан хүний нөөц, нийгмийн хангамжийн 68 хуудас Б тушаал, 2026 оны 1–9 дүгээр сарын цалин бодолтыг хамруулав.
Аудитын арга зүй:	Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу баримт бичгийн шалгалт, банкны хуулгын гүйлгээний 100 хувийн тулгалт, дүн шинжилгээ, харьцуулалт, түүвэрлэлт, ажиглалт, ярилцлагын аргыг хэрэглэж, эрсдэлийн тандалтын зураглал (АБ-2002), илэрсэн асуудлын бүртгэл (АБ-3002)-д үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. ДАДС-ын Стандарт 13.2-ын дагуу төлөвлөлтийн шатанд эрсдэлийн тандалтын зураглал (АБ-2002) гаргаж, худалдан авах ажиллагаа, цалин хөлс, харилцах дансны гүйлгээ, орлого, ил тод байдлыг өндөр эрсдэлтэй чиглэл гэж тодорхойлон аудитын ажлын хөтөлбөрт тусгав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; Татварын ерөнхий хууль; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль; Төрийн хэмнэлтийн тухай хууль; Хөдөлмөрийн тухай хууль; Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль; Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоол; ААТҮГ-ын дүрэм, 2026 оны үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөө. Мөн Сүхбаатар сумын ИТХ-ын 2025.02.12-ны 20 дугаар, 2026.06.29-ний 55 дугаар тогтоол, Засаг даргын 2025.02.19-ний Б/07 захирамж, Хөдөлмөрийн дотоод журам (2025.06.02-ны А/18 тушаалаар шинэчилсэн).
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор Х.Батбаатар 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2026 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэв.

Аудитын стандарт, хараат бус байдал:	Дотоод аудитын Дэлхийн Стандарт (ДАДС, 2024)-ын 5 бүлэг, 15 зарчим, түүний дотор Бүлэг V “Дотоод аудитын үйлчилгээг гүйцэтгэх нь” (Стандарт 13.1–15.2) болон улсын салбарт хэрэгжүүлэх онцлогийг баримтлав. Аудиторт тус байгууллагатай холбоотой ашиг сонирхлын зөрчил, хараат байдлыг алдагдуулах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд аудитыг ДАДС-ын Зарчим 1–5 (ёс зүй, мэргэжлийн зан төлөв) болон Зарчим 7 (бие даасан байдал)-ын дагуу хараат бусаар гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт:	Шатахуун, давс, нормын хувцасны нийлүүлэлтийн бодит тоо хэмжээг газар дээр нь тоолж баталгаажуулаагүй бөгөөд дүгнэлтийг баримт бичиг, банкны хуулга, ярилцлагын нотолгоонд үндэслэв. 2025 оны харилцах дансны хуулга, батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 2025 оны А тушаал (цалин тогтоосон шийдвэр), шагнал урамшууллын шийдвэрийг аудитад ирүүлээгүй тул 2025 оны талаарх дүгнэлтийг цалин бодолтын тайлан, Б тушаалын хуулбарт үндэслэн гаргав. Сумын ИТХ-ын 2025.02.12-ны “Цалин хөлсний жишиг тогтоох тухай” 20 дугаар тогтоол болон түүнийг хүчингүй болгож цалин хөлсний жишгийг шинэчлэн тогтоосон 2026.06.29-ний 55 дугаар тогтоолыг аудитын явцад нэмэлт баримтаар бүрдүүлж, цалингийн хязгаарыг тогтоол тус бүрийн хүчинтэй хугацаагаар тогтооход (Илрүүлэлт 3.2) ашиглав.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Аудитын үндэслэл, зорилго

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 оны дотоод аудитын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ДА-2026/17/YA дугаар удирдамжийн дагуу энэхүү аудитыг гүйцэтгэв. Аудитын зорилго нь ААТҮГ-ын санхүү, үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг магадлах, дотоод хяналтыг сайжруулах, эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ

“Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн ашиглалт, устгал, ариутгал, ногоон байгууламж, тохижилтын ажил гүйцэтгэдэг. Байгууллагын дүрмийн 5.2-т иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах замаар өөрийн орлогоо нэмэгдүүлэх, ашигт үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулж, өөрийгөө бүрэн санхүүжүүлэх зорилтыг тусгасан байна.

2026 оны үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөгөөр 60 ажилтан (удирдах 1, үйлчлэх 59) батлагдсан бөгөөд үйл ажиллагааг дараах 3 чиглэлээр төлөвлөжээ:

- А1. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ – 807,148.5 мянган төгрөг;
- А2. Төвлөрсөн хогийн цэгийн устгал, ариутгал, ашиглалт – 774,469.0 мянган төгрөг;
- А3. Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ – 925,658.2 мянган төгрөг.

1.3. Удирдлага, эрх зүйн орчин

ААТҮГ-ыг захирал Д.Цэлмэг удирдаж, санхүүгийн бүртгэлийг нягтлан бодогч Ц.Ариунзул хөтөлж байна. Байгууллага нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажилладаг. Төсвийн санхүүжилтийг Сүхбаатар сумын ЗДТГ-аас сар бүр олгодог.

1.4. Аудитын ажлын эрсдэлийн үнэлгээ (Стандарт 13.2)

Төлөвлөлтийн шатанд байгууллагын үйл ажиллагааны урсгал (АБ-2002), 2026 оны төсөв, харилцах дансны хуулга, 2025 оны цалин бодолтын тайлан, хүний нөөцийн тушаалд дүн шинжилгээ хийж, аудитын зорилгод нөлөөлөх гол эрсдэлүүдийг тодорхойлон ажлын хөтөлбөрт тусгав. Тодорхойлсон эрсдэл бүр аудитын явцад бодит илрүүлэлтээр батлагдсан эсэхийг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Аудитын ажлын эрсдэлийн үнэлгээ ба үр дүн

Үйл явц	Тодорхойлсон эрсдэл	Урьдчилсан үнэлгээ	Аудитын үр дүн
Худалдан авах ажиллагаа	Тендерийн журам зөрчигдөх, гэрээний нөхцөлгүй төлбөр хийгдэх	Өндөр	Батлагдсан: 3.1
Цалин хөлс, хүний нөөц	Бүрэн эрхээс хэтэрсэн цалин, үндэслэлгүй нэмэгдэл олгогдох	Өндөр	Батлагдсан: 3.2, 3.4, 3.7, 3.11
Харилцах дансны гүйлгээ, зардал	Анхан шатны баримтгүй зарцуулалт хийгдэх	Өндөр	Батлагдсан: 3.3, 3.6, 3.8
Орлого, хураамж	Орлого дутуу бүртгэгдэх, авлага хяналтгүй болох	Дунд	Батлагдсан: 3.5, 3.9
Ил тод байдал	Шилэн данс, цахим хуудасны мэдээлэл дутуу байх	Дунд	Батлагдсан: 3.10

1.5. Аудитын явцад удирдлагын анхааралд хүргэх асуудал

2025 оны хүний нөөц, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал болон 2026 оны цалин бодолтыг тулган баталгаажуулахад дараах хоёр асуудал ажиглагдсан. Эдгээрийг аудитын зөрчилд тооцоогүй боловч удирдлага цаашид анхаарч ажиллах шаардлагатай:

•**Буцалтгүй тусламж:** 2025 онд захирлын 8 тушаалаар нийт 3,100.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Үүнээс захирал Д.Цэлмэг өөрийн эцэгт 300.0 мянган төгрөгийн тусламж олгох тушаал (2025.10.06-ны Б/49) гаргасан, мөн нягтлан бодогч Ц.Ариунзулд 1,000.0 мянган төгрөгийн тусламж олгох тушаалаар (2025.10.20-ны Б/54) уг зардлыг гаргахыг тусламж хүлээн авагч нягтлан бодогчид өөрт нь даалгасан байна. Гэр бүлийн гишүүн хагалгаанд орсон үндэслэлээр тусламж олгосон 4 тушаалд ХДЖ-ийн 8.2.7 дахь заалтын оронд 8.2.6, 7.2.5 дахь заалтыг үндэслэж, нотлох баримт хавсаргаагүй байна. Иймд ХДЖ-ийн 8.2.6–8.2.8, 8.3.4 дэх заалтад хамаарах нотлох баримтыг бүрдүүлж, шийдвэр гаргагч болон нягтлан бодогч өөрт нь хамаарах тусламжийн асуудлыг өмчлөгчийн төлөөлөл эсхүл захирлын дэргэдэх зөвлөлөөр хянуулах журам тогтоох шаардлагатай.

•**Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл:** 2025.01.13-ны Б/05, 2025.03.03-ны Б/09 болон 2024 оны тушаалаар ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 40 хувиар тогтоосон боловч уг хэмжээг ХДЖ, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй байна. Иймд нэмэгдлийн хэмжээг Хөдөлмөрийн тухай хуулийн 56.2, 109.6, ХДЖ-ийн 7.3 дахь заалттай уялдуулан холбогдох гэрээ, журамд тусгах шаардлагатай.

2. АУДИТЫН ҮР ДҮН

2.1. Төсөв, санхүүжилтийн гүйцэтгэл

Сүхбаатар сумын Засаг даргын баталсан 2026 оны төсөв 2,507,275.7 мянган төгрөг бөгөөд зардлын 63.5 хувийг цалин хөлс, 9.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэл (НДШ), 27.3 хувийг бараа, үйлчилгээний зардал эзэлж байна.

Хүснэгт 2. 2026 оны төсвийн бүтэц /мянган төгрөгөөр/

Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Эзлэх хувь
Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	1,592,976.0	63.5%
Ажил олгогчоос төлөх НДШ	230,982.0	9.2%
Бараа, үйлчилгээний зардал	683,317.7	27.3%
үүнээс: шатахуун	216,487.2	8.6%
үүнээс: өвлийн бэлтгэл (давс, бодис г.м.)	73,500.0	2.9%
үүнээс: сэлбэг	65,460.0	2.6%
үүнээс: нормын хувцас	50,700.0	2.0%
Нийт	**2,507,275.7**	**100.0%**

Харилцах дансны хуулгаар 2026 оны 1–8 дугаар сард ЗДТГ-аас 1,673,890.6 мянган төгрөгийн санхүүжилт (татаас) хүлээн авсан нь жилийн төсвийн 66.8 хувь байна. 9 дүгээр сарын санхүүжилт 2026.09.30-ны байдлаар орж ирээгүй бөгөөд тус сард цалингийн урьдчилгаа, “цалингийн зээл” гэсэн утгатай гүйлгээ хийгдэж, дансны үлдэгдэл 13,079.2 мянган төгрөг болж буурсан байна.

Хүснэгт 3. Төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Сар	ЗДТГ-ын санхүүжилт	Хуримтлагдсан дүн
1 дүгээр сар	152,694.7	152,694.7
2 дугаар сар	326,223.6	478,918.3
3 дугаар сар	185,595.3	664,513.6
4 дүгээр сар	195,595.4	860,109.0
5 дугаар сар	225,595.4	1,085,704.4
6 дугаар сар	206,995.4	1,292,699.8
7 дугаар сар	195,595.4	1,488,295.2
8 дугаар сар	185,595.4	1,673,890.6
9 дүгээр сар	–	1,673,890.6
Нийт	**1,673,890.6**	**Төсвийн 66.8%**

Мөн хугацаанд хог тээвэр, ногоон байгууламжийн гэрээт ажил, техник түрээснээс 27,217.6 мянган төгрөгийн өөрийн орлого орсон нь нийт орлогын 1.6 хувь бөгөөд дүрмээр хүлээсэн өөрийгөө санхүүжүүлэх зорилтоос хол байна (Илрүүлэлт 3.5).

2025 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, харилцах дансны хуулгыг аудитад ирүүлээгүй тул 2025 оны төсөв, санхүүжилтийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байсан бөгөөд дараагийн шатанд шалгах шаардлагатай. 2025 оны цалин хөлсний зардлыг цалин бодолтын тайланд үндэслэн 2.3-т тусгав.

2.2. Худалдан авах ажиллагаа

ААТҮГ нь 2026 онд давс, нормын хувцас, шатахууны нийт 327,187.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 тендер зарласан. Тендерийн баримт бичиг, гэрээ, банкны гүйлгээг тулгахад төлбөрийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт 4. 2026 оны тендер шалгаруулалт ба төлбөрийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Тендер	Төсөвт өртөг	1–9 сард төлсөн	Аудитын ажиглалт
Давс	60,000.0	48,800.0	Гэрээний үнэ 48,800.0 мянган төгрөгийг 2026.02.10, 02.16-нд 100 хувь төлсөн; Давсыг 2 дугаар сард бүрэн хүлээн авсан.
Нормын хувцас	50,700.0	-	Нормын хувцсыг хүлээн аваагүй
Шатахуун	216,487.2	177,661.0	Гэрээ (2026.03.26) байгуулахаас өмнө 54,045.2 мянган төгрөг төлсөн
Нийт	**327,187.2**	**226,461.0**	

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, шийдвэрийн баталгаажуулалт, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл хуулийн шаардлага хангаагүй (Илрүүлэлт 3.1). Түүнчлэн сэлбэг, материал, асфальт, хашаа хаалгыг давтан, хуваан худалдан авсан гүйлгээ ажиглагдсан бөгөөд дараагийн шатны аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай.

2.3. Цалин хөлс, хүний нөөцийн шийдвэр

2026 оны төсөвт цалин хөлсөнд 1,592,976.0 мянган төгрөг тусгасан. Цалин тогтоосон захирлын А/02, нэмэгдэл олгосон Б/01, Б/02 тушаал, Хөдөлмөрийн дотоод журам, цалин бодолтын тайланг тулгахад:

- Сумын ИТХ цалин хөлсний жишгийг 2026.06.29-ний 55 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоохоос өмнө захирлын 2026 оны А/02 тушаалаар цалинг нэмэгдүүлж, тогтоол гарах хүртэлх 1–6 дугаар сард үндсэн цалин болон нэмэгдэл цалинд 171,818.2 мянган төгрөгийг олгосон, тогтоол батлагдсаны дараа А/02 тушаалыг өөрчлөлгүй жишиг цалинг цалин бодолтод шууд мөрдсөн (Илрүүлэлт 3.2)
- Хөдөлмөрийн дотоод журмын 7.7-д заасан 20 хувийн нэмэгдлийг 25 хувиар олгож 1,229.3 мянган төгрөг илүү олгосон (Илрүүлэлт 3.4);
- Жолооч Ц.Наранбаатарт 2026 оны 8, 9 дүгээр сард томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр үндсэн цалингийн 40 хувиар тооцон 1,076.3 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон (Илрүүлэлт 3.7);
- Сахилгын шийтгэлээр үндсэн цалинг бууруулахдаа нэмэгдэл цалингаас суутгасан (Илрүүлэлт 3.11).

2025 оны цалин хөлс. 2025 оны 1–12 дугаар сард сар бүр 50–56 ажилтанд нийт 1,071,399.2 мянган төгрөгийн цалин хөлс бодогдсоноос бодогдсон (ажилласан цагт ногдох) цалин 647,614.7 мянган төгрөг, нийт нэмэгдэл (ээлжийн амралтын олговор орсон) 423,784.6 мянган төгрөг буюу 39.6 хувь, гарт олгосон цалин 804,235.5 мянган төгрөг байна.

Хүснэгт 4а. 2025 оны цалин хөлсний сарын гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Сар	Ажилтан	Бодогдсон цалин	Нийт нэмэгдэл	үүнээс: Нэмэгдэл 1	Олговол зохих
1 дүгээр сар	50	54,650.0	26,260.3	17,924.3	80,910.3
2 дугаар сар	51	53,290.0	24,963.8	15,158.7	78,253.8
3 дугаар сар	53	52,111.9	26,042.4	13,583.9	78,154.3
4 дүгээр сар	52	52,050.0	30,526.4	18,784.5	82,576.4
5 дугаар сар	56	54,832.9	34,535.3	21,646.5	89,368.2
6 дугаар сар	55	53,622.0	41,450.5	28,661.7	95,072.5
7 дугаар сар	55	55,521.4	56,308.2	41,295.6	111,829.7
8 дугаар сар	56	52,415.8	38,998.7	14,978.6	91,414.6
9 дүгээр сар	55	53,387.5	31,528.5	13,347.3	84,916.0
10 дүгээр сар	55	54,647.8	32,570.1	15,062.6	87,218.0
11 дугаар сар	55	55,944.4	31,084.8	18,525.3	87,029.3
12 дугаар сар	55	55,140.9	49,515.5	33,743.1	104,656.4
Нийт	**50–56**	**647,614.7**	**423,784.6**	**252,712.1**	**1,071,399.2**

Эх сурвалж: “Цалин бодолтын тайлан 2025.xlsx”. Тайлбар: дүнг мянгачлан тоймлосноос нийлбэрт 0.1–0.3 мянган төгрөгийн зөрүү гарч болно.

2025 оны 1–9 дүгээр сартай харьцуулахад 2026 оны мөн үеийн олговол зохих цалин 386,810.6 мянган төгрөгөөр буюу 48.8 хувиар өссөн. 2026 онд ажилчдын үндсэн цалинг 1,100.0 мянган төгрөгөөс 1,500.0 мянган төгрөг (36.4 хувь), захирлынхыг 1,600.0 мянган төгрөгөөс 1,900.0 мянган төгрөг (18.8 хувь), нягтлан бодогчийнхыг 1,400.0 мянган төгрөгөөс 1,800.0 мянган төгрөг (28.6 хувь) болгон нэмсэн нь Илрүүлэлт 3.2-т дурдсан асуудлын цар хүрээг харуулж байна (эх сурвалж: 2025 оны 12 дугаар сарын цалин бодолтын тайлан, “2026.01 sar.xlsx” файлын “Үндсэн цалин (B01)” багана).

Хүснэгт 4б. 2025, 2026 оны 1–9 дүгээр сарын цалин хөлсний харьцуулалт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2025 оны 1–9 сар	2026 оны 1–9 сар	Зөрүү	Өөрчлөлт
Тушаалаар тогтоосон үндсэн цалингийн нийлбэр	544,752.0	773,556.9	228,804.9	42.0%
Бодогдсон (ажилласан цагт ногдох) цалин	481,881.5	681,797.0	199,915.5	41.5%
Нийт нэмэгдэл (ээлжийн амралтын олговор орсон)	310,614.1	497,509.2	186,895.1	60.2%
Олговол зохих цалин	792,495.6	1,179,306.2	386,810.6	48.8%

Эх сурвалж: 2025, 2026 оны цалин бодолтын тайлан.

2.4. Нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт

Анхан шатны баримтын бүрдэл, бүртгэлийн чанарт дараах зөрчил илэрлээ: 19,112.0 мянган төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэлгүй гаргасан (Илрүүлэлт 3.3); 39,303.2 мянган төгрөгийн 37 баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн (Илрүүлэлт 3.6); согтууруулах ундаа худалдан авахад 174.4 мянган төгрөг зарцуулсан (Илрүүлэлт 3.8); хог хаягдлын хураамжид eBarimt үүсгээгүй, авлагыг төлөгч тус бүрээр бүртгээгүй (Илрүүлэлт 3.9).

2.5. Ил тод байдал, мэдээллийн нээлттэй байдал

Шилэн индексийн үнэлгээ 2026 оны 1 дүгээр улиралд 28 хувь, 2 дугаар улиралд 20 хувь, 3 дугаар улиралд 50 хувь байна. Хуулиар нийтлэх ёстой 5,000.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй 44 гүйлгээний 24 нь мэдээлэгдсэн, 20 нь мэдээлэгдээгүй байна (Илрүүлэлт 3.10).

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

3.1. Илрүүлэлтийн ноцтой байдлыг тогтоох арга зүй

ДАДС-ын Стандарт 14.3-ын дагуу илрүүлэлт бүрийг “бодит байдал, байх ёстой шаардлага (шалгуур), асуудлын үндсэн шалтгаан, байгууллагад үзүүлэх нөлөө (үр дагавар)” бүтцээр баримтжуулж, ноцтой байдлаар нь ангилж эрэмбэлэв. Ноцтой байдлыг эрсдэлийн нөлөөлөл (санхүүгийн дүн, хууль зөрчсөн байдал, нэр хүнд) болон магадлал (давтагдах, үргэлжлэх магадлал)-ыг байгууллагын батлагдсан эрсдэлийн хуваарийн дагуу 1–5 оноогоор үнэлж, үржвэрээр нь (1–25 оноо) тогтоосон: 17–25 оноо – ӨНДӨР (Их), 9–16 оноо – ДУНД, 1–8 оноо – БАГА. Энэ хуваарь нь эрсдэл хяналтын матриц (АБ-2003), эрсдэлийн гүйцэтгэлийн үнэлгээ (АБ-3001)-д ашигласан хуваарьтай ижил бөгөөд илрүүлэлт бүрийн оноо холбогдох эрсдэлийн гүйцэтгэлийн шатны үнэлгээтэй нийцнэ. Үндсэн шалтгааныг “5 яагаад” аргаар удирдлагатай хамтран тодорхойлов. Стандарт 14.4-ийн дагуу илрүүлэлт бүрт шийдвэрлэлт, удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгав.

Хүснэгт 5. Ноцтой байдлын үнэлгээний матриц

Нөлөөлөл \ Магадлал	1 – Маш бага	2 – Бага	3 – Дунд	4 – Өндөр	5 – Маш өндөр
5 – Маш өндөр	**БАГА (5)**	**ДУНД (10)**	**ДУНД (15)**	**ӨНДӨР (20)**	**ӨНДӨР (25)**
4 – Өндөр	**БАГА (4)**	**БАГА (8)**	**ДУНД (12)**	**ДУНД (16)**	**ӨНДӨР (20)**
3 – Дунд	**БАГА (3)**	**БАГА (6)**	**ДУНД (9)**	**ДУНД (12)**	**ДУНД (15)**
2 – Бага	**БАГА (2)**	**БАГА (4)**	**БАГА (6)**	**БАГА (8)**	**ДУНД (10)**
1 – Маш бага	**БАГА (1)**	**БАГА (2)**	**БАГА (3)**	**БАГА (4)**	**БАГА (5)**

Илрүүлэлтүүдийг ноцтой байдлын оноо, дараа нь зөрчлийн дүнгээр буурах дараалаар эрэмбэлэв. “Эх баримт” баганад АБ-3002 ажлын баримт дахь дугаарыг заав.

Хүснэгт 6. Ноцтой байдлаар эрэмбэлсэн илрүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

№	Илрүүлэлт	Нөлөө-лөл	Магад-лал	Ноцтой байдал	Дүн	Эх баримт
1	3.1. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, шийдвэр хууль зөрчсөн	5	4	**ӨНДӨР (20)**	327,187.2	АБ-3002 №4

№	Илрүүлэлт	Нөлөө-лөл	Магад-лал	Ноцтой байдал	Дүн	Эх баримт
2	3.2. Цалингийн жишиг батлагдахаас өмнө эрх хэтрүүлэн цалин тогтоож олгосон	5	4	**ӨНДӨР (20)**	171,818.2	АБ-3002 №7
3	3.3. Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 19,112.0 мянган төгрөг зарцуулсан	5	4	**ӨНДӨР (20)**	19,112.0	АБ-3002 №10
4	3.4. ХДЖ-д заасан 20 хувийн нэмэгдлийг 25 хувиар олгосон	4	4	**ДУНД (16)**	1,229.3	АБ-3002 №3
5	3.7. Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 40 хувийн нэмэгдэл олгосон	4	4	**ДУНД (16)**	1,076.3	АБ-3002 №8
6	3.11. Сахилгын шийтгэлээр үндсэн цалинг бууруулахдаа нэмэгдлээс суутгасан	4	4	**ДУНД (16)**	–	АБ-3002 №9
7	3.5. Дүрмээр хүлээсэн өөрийгөө санхүүжүүлэх зорилт хэрэгжээгүй	3	4	**ДУНД (12)**	–	АБ-3002 №1
8	3.6. Худалдан авалтын 37 баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн	3	3	**ДУНД (9)**	39,303.2	АБ-3002 №6
9	3.9. Хог хаягдлын хураамжид eBarimt үүсгээгүй, авлагын бүртгэл тодорхойгүй	3	3	**ДУНД (9)**	–	АБ-3002 №2
10	3.10. Шилэн индексийн үнэлгээ хангалтгүй	3	3	**ДУНД (9)**	–	АБ-3002 №11
11	3.8. Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авсан	3	2	**БАГА (6)**	174.4	АБ-3002 №5

Илэрсэн асуудал:	**3.1. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, шийдвэр хууль зөрчсөн**
Асуудлын ангилал	Үйл явц: Худалдан авах ажиллагаа. Ноцтой байдал: ӨНДӨР – нөлөөлөл 5 × магадлал 4 = 20; эрэмбэ 1/11 (АБ-3002 №4)

Бодит байдал:
ААТҮГ нь 2026 оны А/01 дугаар тушаал үнэлгээний хороо 5 гишүүнтэй давс (60,000.0 мянган төгрөг), нормын хувцас 2026 оны А/06 дугаар тушаал ажлын хэсэг 5 гишүүнтэй (50,700.0 мянган төгрөг), шатахуун 2026 оны А/04 дугаар тушаал 5 гишүүнтэй (216,487.2 мянган төгрөг) худалдан авах нийт 327,187.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 тендер зарласан. Эдгээр тендерт үнэлгээний хороо байгуулсан захирлын тушаалын хууль зүйн үндэслэл буруу; давс худалдан авах тендерт тендерийн шаардлага хангахгүй гэж үнэлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулсан; үнэлгээний хороо 3 тендерт 100 хувийн ирцтэй хуралдсан боловч үнэлгээний маягтад зөвхөн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсан; нарийн бичгийн даргаас бусад гишүүд “Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар” гаргаагүй зөрчил илэрлээ. Мөн шатахуун нийлүүлэх гэрээг 2026.03.26-нд байгуулсан боловч түүнээс өмнө нийлүүлэгчид 6 удаагийн гүйлгээгээр 54,045.2 мянган төгрөг шилжүүлсэн нь банкны хуулгаар тогтоогдов.

Байх ёстой шаардлага /шалгуур/:
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2-т захиалагч “үнэлгээний хороо байгуулах”, 50 дугаар зүйлийн 50.1-д “Захиалагч энэ хуулийн 10.2-т зааснаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна”, 50.1.1-д “100 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог гурваас доошгүй”, 50.1.2-т “ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй”, 51 дүгээр зүйлийн 51.8-д “Үнэлгээний

хорооны гишүүд хуралд биечлэн оролцсон эсэхээс үл хамааран зөвлөмжтэй танилцаж, түүнийг дэмжих эсэх саналаа тусган цахим системээр баталгаажуулах үүрэгтэй", 52 дугаар зүйлийн 52.1-д худалдан авах ажиллагаанд оролцож буй албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, 28 дугаар зүйлийн 28.1.3-т шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах, 43 дугаар зүйлийн 43.3-т "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно" гэж тус тус заасан.

Асуудлын үндсэн шалтгаан:
Худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтан, үнэлгээний хорооны гишүүдийн хуулийн шаардлагын талаарх мэдлэг, ур чадвар дутмаг; захиалагчийн дотоод хяналт, баримт бичгийн хяналтын хуудас байхгүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:
Худалдан авалт хууль бус болж маргаан үүсэх, шударга өрсөлдөөн алдагдах, ашиг сонирхлын зөрчил илрэхгүй үлдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй.

Аудитын шийдвэрлэлт:
АЛБАН ШААРДЛАГА: 327,187.2 мянган төгрөгийн 3 тендерийн баримт бичгийг хуульд нийцүүлж, үнэлгээний хороог хуулийн 50.1-д заасан бүрэлдэхүүнтэй байгуулах, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг бүрдүүлж, гэрээ байгуулахаас өмнө төлбөр хийхгүй байх.

Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө:
Хариуцагч: Захирал Д.Цэлмэг. Хугацаа: Албан шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног.
Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ: Үнэлгээний хороог хуульд заасны дагуу байгуулж тендерийн баримт бичгийн бүрдлийг үнэлгээний хорооны нарийн бичгийн даргатай хамтран өгөгдсөн хугацаанд залруулан нөхөн (ашиг сонирхлын мэдэгдэл, хурлын тэмдэглэл гэх мэт) бүрдүүлнэ. Цаашид дээрх алдааг давтан гаргахгүй.

Илэрсэн асуудал:	**3.2. Цалингийн жишиг батлагдахаас өмнө эрх хэтрүүлэн цалин тогтоож олгосон**
Асуудлын ангилал	Үйл явц: Цалин хөлс, хүний нөөц. Ноцтой байдал: ӨНДӨР – нөлөөлөл 5 × магадлал 4 = 20; эрэмбэ 2/11 (АБ-3002 №7)

Бодит байдал:
Сумын ИТХ цалин хөлсний жишгийг шинэчлэн тогтоогоогүй байхад захирлын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэтрүүлэн цалин тогтоож, 2026 оны 1–6 дугаар сард нийт 171,818.2 мянган төгрөгийн үндсэн болон нэмэгдэл цалин хөлс олгосон байна. 2026 оны үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд 60 ажилтны цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалд 1,592,976.0 мянган төгрөг (нийт зардлын 63.5 хувь) тусгасан. 2025 онд захирлын цалинг Сүхбаатар сумын Засаг даргын 2025.02.19-ний Б/07 захирамжаар (сумын ИТХ-ын 2025.02.12-ны "Цалин хөлсний жишиг тогтоох тухай" 20 дугаар тогтоолыг үндэслэн) 1,600.0 мянган төгрөг, тус тогтоолоор Нягтлан бодогч 1,400.0, нярав, диспетчер, ХАБЭА инженер, бичиг хэрэг тус бүр 1,300.0, бусад албан хаагчийн цалинг 1,100.0 мянган төгрөгөөр тогтоосон. 2026 оны А/02 тушаалаар захирал 1,900.0, нягтлан бодогч 1,800.0, нярав, диспетчер, ХАБЭА инженер, бичиг хэрэг тус бүр 1,700.0, бусад албан хаагчийн цалинг 1,500.0 мянган төгрөг болгож албан тушаал тус бүрээр 18.8–36.4 хувиар (захирал 18.8, нягтлан бодогч 28.6, нярав, диспетчер, ХАБЭА инженер, бичиг хэрэг 30.8, бусад албан хаагч 36.4 хувь), дунджаар 28.6 хувиар нэмэгдүүлсэн. Сумын ИТХ 2026.06.29-ний 55 дугаар тогтоолоор 20 дугаар тогтоолыг хүчингүй болгож, цалин хөлсний жишгийг захирал 1,900.0, нягтлан бодогч 1,800.0, нярав, хүний нөөц, диспетчер, ХАБЭА, бичиг хэрэг, механикч, дендрологич тус бүр 1,700.0, орлогын байцаагч, хог тээврийн жолооч 1,600.0, бусад албан тушаал 1,566.9 мянган төгрөг, нийт 56 орон тоотойгоор шинэчлэн тогтоосон. Тогтоолд буцаан хэрэглэх заалт байхгүй тул 2026 оны 1 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 29-ний хооронд 20 дугаар тогтоол хүчин төгөлдөр үйлчилж байсан бөгөөд энэ хугацаанд А/02 тушаалаар олгосон 171,818.2 мянган төгрөгийн цалин хөлс эрх бүхий байгууллагын шийдвэрээс өмнө, хугацааны зөрүүтэй олгогдсон байна. 55 дугаар тогтоол батлагдсаны дараа захирал А/02 тушаалд өөрчлөлт оруулаагүй, ажилтан, албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон тушаал гаргаагүй атлаа тогтоолын хавсралтад заасан жишиг цалингийн хэмжээг (тухайлбал, А/02 тушаалаар бусад албан хаагчид тогтоосон 1,500.0 мянган төгрөгийн оронд 1,566.9–1,700.0 мянган төгрөг) цалин бодолтод шууд мөрдсөн байна. ИТХ-ын тогтоол нь цалин хөлсний нийтлэг жишгийг

тогтоох бөгөөд ажилтан тус бүрийн цалинг жишигт багтаан тогтоох нь ТБОНӨТХ-ийн 20.1.4, ХДЖ-ийн 7.1-д заасны дагуу захирлын эрх, үүрэг тул тогтоол батлагдсанаас хойших цалингийн өөрчлөлт захирлын тушаалаар баталгаажаагүй, цалин бодолт анхан шатны баримт (тушаал)-ын үндэслэлгүй хийгдсэн. Мөн тогтоолоор 56 орон тоо баталсан бол 2026 оны үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд 60 ажилтан тусгасан зөрүүтэй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад захирал “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж тус тус заасан. Мөн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.1-д “Ажилтан үндсэн болон нэмэгдэл цалинг тухайн жилийн 1 дүгээр сард холбогдох хууль тогтоомж, заавар журамд нийцүүлэн ажлын үр дүн, ажилласан хугацааг харгалзан захирлын тушаалаар батлан олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан.
Асуудлын үндсэн шалтгаан: Захирал ТБОНӨТХ-ийн 20.1.4-т заасан бүрэн эрхийн хязгаарыг хэтрүүлсэн; цалин нэмэх шийдвэрийг өмчлөгчөөр цалин хөлсний жишгийг урьдчилан шинэчлэн тогтоолгохгүйгээр гаргасан; ИТХ-ын шийдвэр 6 сарын дараа, буцаан хэрэглэх заалтгүй гарсан; тогтоол гарсны дараа цалингийн өөрчлөлтийг захирлын тушаалаар баталгаажуулалгүй цалин бодолтод шууд хэрэгжүүлсэн, нягтлан бодогч цалинг тушаалтай тулгаж хянаагүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: 55 дугаар тогтоол гарахаас өмнөх 1–6 дугаар сард 171,818.2 мянган төгрөгийн цалин хөлс эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр олгогдож, төсвийн хэмнэлтийн шаардлага зөрчигдсөн; тогтоол гарснаас хойших цалин хөлс захирлын тушаалгүйгээр бодогдож, цалингийн зардлын анхан шатны баримтын үндэслэл бүрдээгүй.
Аудитын шийдвэрлэлт: АЛБАН ШААРДЛАГА: А/02 тушаалыг сумын ИТХ-ын 2026.06.29-ний 55 дугаар тогтоолын хавсралтад албан тушаал, орон тоо тус бүрээр нийцүүлэн өөрчилж, тогтоол батлагдсанаас хойш тушаалгүйгээр жишгээр бодож олгосон цалинг захирлын тушаалаар баталгаажуулах; 2026 оны цалингийн сан, бүдүүвчийг үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгуулан Засаг даргаар батлуулах; тогтоол гарахаас өмнө олгосон 171,818.2 мянган төгрөгийн асуудлыг өмчлөгчөөр (сумын ИТХ) хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Захирал Д.Цэлмэг. Хугацаа: 2026.12.31. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Сумын ИТХ-ын 2026.06.29-ний 55 дугаар тогтоолоор цалингийн нийтлэг жишиг батлагдсан тул А/02 тушаалыг тогтоолын хавсралтад албан тушаал, орон тоо тус бүрээр нийцүүлэн өөрчилж, тогтоол батлагдсанаас хойш жишгээр бодож олгосон цалинг тушаалаар баталгаажуулж, 2026 оны цалингийн сан, бүдүүвчийг үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгуулан Засаг даргаар батлуулна. Тогтоол гарахаас өмнө 1–6 дугаар сард олгосон 171,818.2 мянган төгрөгийн асуудлыг өмчлөгчийн шийдвэрээр шийдвэрлүүлэхээр сумын ИТХ-д хүсэлт хүргүүлнэ. Цаашид цалин, нэмэгдэл тогтоох шийдвэрийг ИТХ-ын тогтоосон жишиг, цалингийн сангийн хүрээнд гаргаж ажиллана.

Илэрсэн асуудал:	**3.3. Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 19,112.0 мянган төгрөг зарцуулсан**
Асуудлын ангилал	Үйл явц: Харилцах дансны гүйлгээ, зардал. Ноцтой байдал: ӨНДӨР – нөлөөлөл 5 × магадлал 4 = 20; эрэмбэ 3/11 (АБ-3002 №10)
Бодит байдал:	

Тээврийн зардалд 4,730.0 (Тээврийн зардал 2026 оны 1/23-нд 1,500.0, 03/05-нд 130.0, 04/03-нд 500.0, 05/02-нд 500.0, 05/19-нд 500.0, 05/24-нд 1,500.0, 06/09-нд 100.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн), гадаад томилолтод 3,132.0, бусад зардалд 11,250.0, нийт 19,112.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан. Гадаад томилолтын 3,132.0 мянган төгрөгийг 2026.06.11-нд хувь хүний дансанд “Томилолтын зардал” гэсэн утгаар шилжүүлсэн.
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” үүрэгтэй гэж тус тус заасан. Түүнчлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх, Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 5.4-т хурал, сургалт, семинар, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулахыг тус тус үүрэг болгосон.
Асуудлын үндсэн шалтгаан: Гүйлгээ хийхээс өмнө баримтын бүрдлийг хянах урьдчилсан хяналт хэрэгжээгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Зардлын бодит байдал нотлогдохгүй, төсвийн хөрөнгө зориулалтын бусаар зарцуулагдах, санхүүгийн тайлан бодит бус болох эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт: АЛБАН ШААРДЛАГА: 19,112.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг (гэрээ, нэхэмжлэх, гүйцэтгэлийн акт, томилолтын удирдамж, тайлан, төлбөрийн баримт) нөхөн бүрдүүлж, баримтаар нотлогдоогүй дүнг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх; цаашид анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг хийхгүй байх.
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул. Хугацаа: Албан шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Алдааг давтан гаргахгүй дутуу баримтын бүрдлийг өгөгдсөн хугацаанд бүрэн бүрдүүлж ажиллана.

Илэрсэн асуудал:	**3.4. ХДЖ-д заасан 20 хувийн нэмэгдлийг 25 хувиар олгосон**
Асуудлын ангилал	Үйл явц: Цалин хөлс, хүний нөөц. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 4 × магадлал 4 = 16; эрэмбэ 4/11 (АБ-3002 №3)
Бодит байдал: ААТҮГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.7-д заасан 20 хувийн нэмэгдлийг захирлын 2026 оны Б/01, Б/02 тушаалаар 25 хувиар тогтоож олгосон. Хэтрүүлэн олгосон 5 хувийн зөрүү 1,229.3 мянган төгрөг байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: ТБОНӨТХ-ийн 20.1.4-т захирал “эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох”, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.7-д ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар олгохоор тус тус заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Захирал байгууллагын дотоод журмыг зөрчиж шийдвэр гаргасан; нягтлан бодогч цалин бодохдоо тушаал хууль, журамд нийцэж буй эсэхийг урьдчилан хянаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Цалингийн сан үндэслэлгүйгээр нэмэгдэж, байгууллагад 1,229.3 мянган төгрөгийн хохирол учирсан.	
Аудитын шийдвэрлэлт: ТӨЛБӨРИЙН АКТ: 1,229.3 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Б/01, Б/02 тушаалыг ХДЖ-д нийцүүлэн өөрчлөх.	
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө:	

Хариуцагч: Захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул. Хугацаа: Акт гардуулснаас хойш 30 хоног. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Ур чадварын нэмэгдлийг ямар тохиолдолд олгох хэдэн хувиар олгохоо ХДЖ-даа өөрчлөлт оруулах замаар тодорхой тусган ажиллана. Актын төлбөрийг тогтоосон хугацаанд нь байгууллагын төсөвт төвлөрүүлэн ажиллана.

Илэрсэн асуудал:	**3.5. Дүрмээр хүлээсэн өөрийгөө санхүүжүүлэх зорилт хэрэгжээгүй**
Асуудлын ангилал	Үйл явц: Орлого, хураамж. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 3 × магадлал 4 = 12; эрэмбэ 7/11 (АБ-3002 №1)
Бодит байдал: ААТҮГ-ын дүрэмд ашигт үйл ажиллагааг тасралтгүй, үр ашигтай зохион байгуулж, өөрийгөө бүрэн санхүүжүүлэхээр заасан боловч төсвөөс 100 хувийн санхүүжилт (татаас) авч байна. 2026 оны 1–8 дугаар сард Сүхбаатар сумын ЗДТГ-аас 1,673,890.6 мянган төгрөгийн санхүүжилт (татаас) авсан бол хог тээвэр, ногоон байгууламж, техник түрээсийн өөрийн орлого 27,217.6 мянган төгрөг буюу нийт орлогын 1.6 хувь байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: “Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Үйлдвэрийн газар нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ: 5.2.1. иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг бий болгож, өөрийн орлогоо нэмэгдүүлэх; 5.2.2. ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, ашигт үйл ажиллагааг тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах замаар өөрийгөө бүрэн санхүүжүүлэх” гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Үйлчилгээний төлбөр, хураамжийн тариф, гэрээт үйлчилгээний бодлого тодорхойгүй; бизнес төлөвлөгөөнд өөрийн орлогын зорилт тусгаагүй; удирдлага төсвийн татаасаас хамааралтай ажиллах хандлагатай.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Орон нутгийн төсөвт байнгын дарамт үүсэж, ААТҮГ-ын эдийн засгийн бие даасан байдал, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зорилго алдагдана.	
Аудитын шийдвэрлэлт: ЗӨВЛӨМЖ: Өөрийн орлогыг нэмэгдүүлэх (гэрээт хог тээвэр, тохижилт, техник түрээс) төлөвлөгөө боловсруулж, үйлдвэрлэл, санхүүжилтийн жилийн төлөвлөгөөнд хэмжигдэхүйц зорилт тусгаж, өмчлөгчөөр батлуулах.	
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Захирал Д.Цэлмэг. Хугацаа: 2027 оны 1 дүгээр улирал. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** 2027 оны Санхүүгийн төлөвлөгөөндөө өөрийн орлогыг хэрхэн нэмэгдүүлэх талаар тодорхой тусгаж үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх чиглэл рүү түлхүү анхаарч ажиллана.	

Илэрсэн асуудал:	**3.6. Худалдан авалтын 37 баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн**
Асуудлын ангилал	Үйл явц: Харилцах дансны гүйлгээ, зардал. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 3 × магадлал 3 = 9; эрэмбэ 8/11 (АБ-3002 №6)
Бодит байдал: Худалдан авалтын 39,303.2 мянган төгрөгийн 37 баримтыг нэр төрөл, тоо хэмжээгээр задлалгүй бөөн дүнгээр бүртгэсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д татвар төлөгч “анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх” үүрэгтэй гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан:	

Нягтлан бодогч анхан шатны баримтыг нэр төрөл, тоо хэмжээгээр нь задалж бүртгэх шаардлагыг мөрдөөгүй; нийлүүлэгчээс НӨАТ-ын баримт шаардаагүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Бараа материалын хөдөлгөөн, үлдэгдэл хяналтгүй болох, НӨАТ-ын баримтгүй зардал хүлээн зөвшөөрөгдөхгүй байх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт: АЛБАН ШААРДЛАГА: 39,303.2 мянган төгрөгийн 37 баримтыг нийлүүлэгчээс нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн задаргаатай баримт (eBarimt, нэхэмжлэх, зарлагын баримт)-аар нөхөн бүрдүүлж, бараа материалыг нэр төрөл, тоо хэмжээгээр нь залруулан бүртгэх.
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Нягтлан бодогч Ц.Ариунзул. Хугацаа: Албан шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Албан шаардлагад дурдсан баримтуудыг харилцагч байгууллага, иргэнд хүсэлт илгээн нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн задаргаатай болгож цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй.

Илэрсэн асуудал:	**3.7. Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 40 хувийн нэмэгдэл олгосон**
Асуудлын ангилал	Үйл явц: Цалин хөлс, хүний нөөц. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 4 × магадлал 4 = 16; эрэмбэ 5/11 (АБ-3002 №8)
Бодит байдал: Хог тээврийн жолооч Ц.Наранбаатарт 2026 оны 8, 9 дүгээр сард томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр үндсэн цалингийн 40 хувиар тооцон 1,076.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. Шалгагдагч байгууллагын тайлбараар уг нэмэгдлийг жолооч Ц.Наранбаатарт хог тээврийн үндсэн ажлаас гадна нохой устгалын ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл болгон олгосон бөгөөд байгууллагын бүтцэд нохой устгалын ажилтны орон тоо батлагдаагүй тул уг ажлыг жолоочоор гүйцэтгүүлсэн гэжээ. Гэвч ажил хавсран гүйцэтгүүлэх, нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон захирлын тушаал, хөдөлмөрийн гэрээний нэмэлт өөрчлөлт гараагүй, нэмэгдлийг цалингийн программд шууд оруулж бодсон тул нэмэгдэл олгох үндэслэл баримтаар нотлогдохгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: ТБОНӨТХ-ийн 20.1.4; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”; байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.1-д “Ажилтан үндсэн болон нэмэгдэл цалинг тухайн жилийн 1 дүгээр сард холбогдох хууль тогтоомж, заавар журамд нийцүүлэн ажлын үр дүн, ажилласан хугацааг харгалзан захирлын тушаалаар батлан олгоно” гэж тус тус заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Цалин бодолтыг захирлын тушаалтай тулгаж хянаагүй; томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр цалингийн программд нэмэгдлийн хувийг оруулж бодсон.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Байгууллагад 1,076.3 мянган төгрөгийн хохирол учирч, цалингийн зардал хяналтгүй өсөх эрсдэлтэй.	
Аудитын шийдвэрлэлт: ТӨЛБӨРИЙН АКТ: 1,076.3 мянган төгрөгийг холбогдох ажилтан, албан тушаалтнаар нөхөн төлүүлж, нэмэгдлийг зөвхөн захирлын тушаалаар тогтоож олгох.	
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул. Хугацаа: Акт гардуулснаас хойш 30 хоног. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** 2027 оны цалингийн сан, орон тоо бүтцийг батлуулахдаа нохой устгалын ажилтны орон тоог нэмэгдүүлэх хүсэлтийг ИТХ-д уламжлан шийдвэрлүүлж ажиллана. Актын төлбөрийг тогтоосон хугацаанд байгууллагын төсөвт төвлөрүүлэн ажиллана.	

Илэрсэн асуудал:	**3.8. Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авсан**
Асуудлын ангилал	Үйл явц: Харилцах дансны гүйлгээ, зардал. Ноцтой байдал: БАГА – нөлөөлөл 3 × магадлал 2 = 6; эрэмбэ 11/11 (АБ-3002 №5)
Бодит байдал: Захирлын 2026 оны А/05 дугаар тушаалаар ахмад настанд “Сар шинэ”-ийн баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд зориулан 174.4 мянган төгрөгийн 16 шил архи худалдан авсан. Төлбөрийг 2026.02.12-нд “ахмадуудад” гэсэн утгаар шилжүүлсэн нь банкны хуулгаар батлагдав.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7-д “байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах” гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Удирдлага Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хоригийг харгалзаагүй; нягтлан бодогч гүйлгээг урьдчилан хянаагүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хуулиар хориглосон зардал гарч, төсвийн хөрөнгө зориулалтын бусаар зарцуулагдсан.	
Аудитын шийдвэрлэлт: ТӨЛБӨРИЙН АКТ: 174.4 мянган төгрөгийг шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх.	
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Захирал Д.Цэлмэг. Хугацаа: Акт гардуулснаас хойш 30 хоног. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Актын төлбөрийг тогтоосон хугацаанд байгууллагын төсөвт төвлөрүүлж дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллана.	

Илэрсэн асуудал:	**3.9. Хог хаягдлын хураамжид eBarimt үүсгээгүй, авлагын бүртгэл тодорхойгүй**
Асуудлын ангилал	Үйл явц: Орлого, хураамж. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 3 × магадлал 3 = 9; эрэмбэ 9/11 (АБ-3002 №2)
Бодит байдал: ААТҮГ нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системээр (eBarimt) үүсгэдэггүй тул хураамжийн өртэй айл өрхөөс авах авлагын бүртгэл тодорхойгүй байна. Аж ахуйн нэгжээс хог тээвэрлэлтийн төлбөрийг харилцах дансанд жижиг дүнгээр (20.0–600.0 мянган төгрөг) хүлээн авч байгаа боловч төлбөрийн баримт олгоогүй, төлөгч тус бүрээр авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6-д “цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ үзүүлэх”-ийг албан татвар ногдох үйлчилгээнд хамааруулж, 8 дугаар зүйлийн 8.1.1-д албан татварыг “бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд” ногдуулахаар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” үүрэгтэй гэж тус тус заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Хураамжийн тооцоог цахим системээр хөтлөх журам, хариуцсан ажилтан тогтоогоогүй; НББ-ийн программд авлагыг харилцагчаар бүртгэдэггүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Орлого дутуу бүртгэгдэх, хураамжийн өр нэхэмжлэгдэхгүй хуримтлагдах, татварын хариуцлага хүлээх эрсдэлтэй.	
Аудитын шийдвэрлэлт: ЗӨВЛӨМЖ: Хураамж, төлбөр бүрд eBarimt үүсгэж, айл өрх, байгууллагаар авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, улирал бүр тооцоо нийлэх.	
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө:	

Хариуцагч: Нягтлан бодогч Ц.Ариунзул. Хугацаа: 2026.12.31. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ**: Хог хаягдлын хураамжийн төлбөрийг өрх бүрээр цахим төлбөрийн баримтын системээр (eBarimt) үүсгэх талаарх татварын газар болон Сүхбаатар сумын санхүүгийн албатай хамтран ажиллаж шийдвэрлэнэ.

Илэрсэн асуудал:	**3.10. Шилэн индексийн үнэлгээ хангалтгүй**
Асуудлын ангилал	Үйл явц: Ил тод байдал. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 3 × магадлал 3 = 9; эрэмбэ 10/11 (АБ-3002 №11)
Бодит байдал: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтээр (shilen.gov.mn) шилэн индексийн үнэлгээ 2026 оны 1 дүгээр улиралд 28 хувь, 2 дугаар улиралд 20 хувь, 3 дугаар улиралд 50 хувь гэж тус тус үнэлэгдсэн нь мэдээллийн ил тод байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Шилэн дансны тулгалтаар 5,000.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй 44 гүйлгээний 20 нь (үүнд ЗДТГ-аас хүлээн авсан сарын санхүүжилтийн орлого хамаарна) мэдээлэгдээгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3–8.6-д мэдээлэл хариуцагч хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээ болон эрхлэх асуудлын хүрээний мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгахаар; Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын 3.1-д мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулж, тогтмол шинэчлэхээр, 3.2-т нээлттэй мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд, бусад мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол хяналт тавихаар тус тус заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн данс, цахим хуудасны мэдээллийг хариуцсан ажилтан, хугацаат хуваарь тогтоогоогүй; удирдлагын хяналт сул.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Олон нийтийн хяналт хэрэгжих боломж хязгаарлагдаж, байгууллагын нэр хүнд, итгэл буурна.	
Аудитын шийдвэрлэлт: ЗӨВЛӨМЖ: Мэдээлэл хариуцах ажилтныг тушаалаар томилж, хуулийн хугацаанд мэдээллийг байршуулж, улирал бүр хяналт тавих.	
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Мэдээлэл хариуцсан ажилтан. Хугацаа: 2026.12.31, цаашид улирал бүр. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Мэдээлэл хариуцах ажилтныг тушаалаар томилж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	

Илэрсэн асуудал:	**3.11. Сахилгын шийтгэлээр үндсэн цалинг бууруулахдаа нэмэгдлээс суутгасан**
Асуудлын ангилал	Үйл явц: Цалин хөлс, хүний нөөц. Ноцтой байдал: ДУНД – нөлөөлөл 4 × магадлал 4 = 16; эрэмбэ 6/11 (АБ-3002 №9)
Бодит байдал: 2026 оны Б/09, Б/16, Б/17, Б/18, Б/27 дугаар тушаалаар С.Энхбат, Ж.Мөнхдэлгэр, Б.Жаргалсайхан, Б.Болдбаатар, С.Чулуунбаатар нарт үндсэн цалинг 10–20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг хэрэгжүүлэхдээ хуульд заасны дагуу үндсэн цалингаас бус, нэмэгдэл цалин хөлснөөс суутган тооцсон байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3-т сахилгын шийтгэлийн нэг төрөл болох “үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах”-ыг заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Сахилгын шийтгэлийн шийдвэрийг цалингийн тооцоонд хэрхэн тусгах заавар байхгүй; нягтлан бодогч хуулийн заалтыг буруу хэрэглэсэн.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	

Шийтгэлийн шийдвэр хуульд нийцээгүй хэрэгжиж, ажилтны эрх зөрчигдөх, хөдөлмөрийн маргаан үүсэх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт: ЗӨВЛӨМЖ: Сахилгын шийтгэлийг үндсэн цалингаас тооцож, буруу суутгасан дүнг залруулах.
Удирдлагын хариу, үйл ажиллагааны төлөвлөгөө: Хариуцагч: Нягтлан бодогч Ц.Ариунзул. Хугацаа: 2026.12.31. **Удирдлагын байр суурь, авсан арга хэмжээ:** Албан хаагч нарт сахилгын шийтгэл ногдуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн зүйл заалтыг чанд мөрдөж ажиллана. Цаашид суутгалыг үр дүнгийн нэмэгдлээс бус үндсэн цалингаас тооцон суутгана.

4. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

“Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 он, 2026 оны 1–9 дүгээр сарын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар нийт 559,900.6 мянган төгрөгийн 11 зөрчил, дутагдал илэрсэн. Үүнээс 2,480.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 557,420.6 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, мөнгөн дүнгүй 4 асуудалд зөвлөмж өгч шийдвэрлэв.

Хүснэгт 7. Илрүүлсэн зөрчил, шийдвэрлэлтийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

№	Илрүүлэлт	Ноцтой байдал	Шийдвэрлэлт	Дүн
1	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, шийдвэр хууль зөрчсөн	ӨНДӨР	Албан шаардлага	327,187.2
2	Цалингийн жишиг батлагдахаас өмнө эрх хэтрүүлэн цалин тогтоож олгосон	ӨНДӨР	Албан шаардлага	171,818.2
3	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 19,112.0 мянган төгрөг зарцуулсан	ӨНДӨР	Албан шаардлага	19,112.0
4	ХДЖ-д заасан 20 хувийн нэмэгдлийг 25 хувиар олгосон	ДУНД	Төлбөрийн акт	1,229.3
5	Дүрмээр хүлээсэн өөрийгөө санхүүжүүлэх зорилт хэрэгжээгүй	ДУНД	Зөвлөмж	–
6	Худалдан авалтын 37 баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн	ДУНД	Албан шаардлага	39,303.2
7	Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 40 хувийн нэмэгдэл олгосон	ДУНД	Төлбөрийн акт	1,076.3
8	Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авсан	БАГА	Төлбөрийн акт	174.4
9	Хог хаягдлын хураамжид eBarimt үүсгээгүй, авлагын бүртгэл тодорхойгүй	ДУНД	Зөвлөмж	–
10	Шилэн индексийн үнэлгээ хангалтгүй	ДУНД	Зөвлөмж	–
11	Сахилгын шийтгэлээр үндсэн цалинг буруулахдаа нэмэгдлээс суутгасан	ДУНД	Зөвлөмж	–

Шийдвэрлэлтийн төрөл	Өндөр	Дунд	Бага	Тоо	Дүн
Төлбөрийн акт		2	1	3	2,480.0
Албан шаардлага	3	1		4	557,420.6
Зөвлөмж		4		4	–
Нийт	**3**	**7**	**1**	**11**	**559,900.6**

5. ДҮГНЭЛТ

5.1. Сайшаал, эерэг талууд

ААТҮГ нь сумын хог хаягдлын тээвэрлэлт, гудамж талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн үндсэн үйлчилгээг тасралтгүй үзүүлж, 2026 онд гол бараагаа тендерийн аргаар худалдан авах ажиллагааг эхлүүлсэн, ногоон байгууламж, тохижилтын гэрээт ажлаар өөрийн орлого олж эхэлсэн, буруу шилжүүлсэн гүйлгээг тухай бүр залруулж байгаа нь эерэг байна. Аудитын явцад удирдлага, ажилтнууд шаардлагатай баримт материалыг гарган өгч хамтран ажилласанд талархал илэрхийлье.

5.2. Засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үр нөлөөний үнэлгээ

ДАДС-ын Стандарт 14.5, 15.1-ийн дагуу аудитад хамрагдсан үйл ажиллагааны засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцын үр нөлөөг үнэлэв.

Хүснэгт 8. Засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үр нөлөөний үнэлгээ

Бүрэлдэхүүн	Үйл явц	Үнэлгээ	Үндэслэл
Засаглал	Удирдлагын шийдвэр, бүрэн эрхийн хэрэгжилт, бизнес төлөвлөлт	**САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ**	Илрүүлэлт 3.2, 3.4, 3.5
Эрсдэлийн удирдлага	Худалдан авалт, цалин, төлбөрийн эрсдэлийг урьдчилан тодорхойлж хянах механизм	**САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ**	Илрүүлэлт 3.1, 3.2, 3.3
Хяналт	Худалдан авах ажиллагаа	**ХАНГАЛТГҮЙ**	Илрүүлэлт 3.1
Хяналт	Цалин хөлс, хүний нөөцийн шийдвэр	**ХАНГАЛТГҮЙ**	Илрүүлэлт 3.2, 3.4, 3.7, 3.11
Хяналт	Нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт	**САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ**	Илрүүлэлт 3.3, 3.6, 3.8, 3.9
Хяналт	Ил тод байдал, мэдээллийн нээлттэй байдал	**САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ**	Илрүүлэлт 3.10
Хяналт	Төсвийн санхүүжилтийн орлого, харилцах дансны тооцоо	**ХЭСЭГЧЛЭН ХАНГАЛТТАЙ**	ЗДТГ-ын санхүүжилтийн орлого дансанд бүрэн тусгагдсан; буруу шивсэн, илүү шилжүүлсэн гүйлгээг (10,200.0 болон 2,795.3 мянган төгрөг) тухай бүр буцаан залруулсан нь хяналт хэсэгчлэн үр дүнтэй ажиллаж байгааг харуулна.

5.3. Аудитын ажлын ерөнхий дүгнэлт

Илрүүлэлтүүдийн нийлбэр ноцтой байдлыг харгалзан аудитын ажлын ерөнхий дүгнэлтийг дараах 4 түвшний шатлалаар гаргаж, сонгосон түвшинг “►” тэмдгээр тэмдэглэв.

Үнэлгээний түвшин	Тайлбар
ХАНГАЛТТАЙ	Засаглал, эрсдэлийн удирдлага, хяналт үр дүнтэй; илрүүлэлт байхгүй эсвэл бага ач холбогдолтой.
ХЭСЭГЧЛЭН ХАНГАЛТТАЙ	Ихэнх хяналт үр дүнтэй; дунд түвшний цөөн илрүүлэлттэй.
► САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ	**Өндөр түвшний илрүүлэлттэй; хяналтын дутагдал зарим үйл явцад давтагдсан шинжтэй.**
ХАНГАЛТГҮЙ	Хяналтын тогтолцоо ерөнхийдөө үр нөлөөгүй; зорилгод хүрэхэд ноцтой эрсдэл учруулж байна.

Дүгнэлт:“Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явц нь “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” түвшинд байна. Худалдан авах ажиллагаа, цалин хөлсний хяналт хангалтгүй бөгөөд өндөр түвшний 3 илрүүлэлт нь удирдлагын бүрэн эрхийн хэрэгжилт, урьдчилсан хяналтын сул байдлаас үүдэлтэй тул эдгээрийг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай. Илрүүлэлтүүд нь тухайн байгууллагын үйл ажиллагааны түвшинд мэдэгдэхүйц нөлөөтэй боловч сумын төсвийн хэмжээнд хяналтын арга хэмжээгээр залруулах боломжтой. Цалин, нэмэгдэл тогтоох шийдвэрт давтан илэрсэн дутагдал (Илрүүлэлт 3.2, 3.4, 3.7) нь урьдчилсан хяналтын сул байдал тогтмол шинжтэй байгааг харуулж байна.

6. ЗӨВЛӨМЖ

6.1. Үндсэн шалтгааныг шийдвэрлэх зөвлөмж (Стандарт 14.4)

- **Бүрэн эрхийн хүрээг хангах:** Сумын ИТХ-ын 2026 оны 55 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоосон цалин хөлсний жишигт нийцүүлэн цалингийн сан, бүдүүвчийг Засаг даргаар батлуулж, захирлын гаргах цалин, нэмэгдлийн тушаалыг Хөдөлмөрийн дотоод журам, ТБОНӨТХ-ийн 20.1.4-т нийцүүлэх; өөрийн орлогын зорилтыг бизнес төлөвлөгөөнд тусгаж батлуулах.
- **Худалдан авах ажиллагааны хяналт:** Үнэлгээний хороог хуулийн 50.1-д заасан бүрэлдэхүүнтэй байгуулж, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг бүрдүүлэх; гэрээ байгуулахаас өмнө төлбөр хийхгүй, барааг хүлээлцэх актаар хүлээн авч байж төлбөр хийх.
- **Урьдчилсан хяналт, баримтын бүрдэл:** Гүйлгээ бүрийг анхан шатны баримттай тулгаж урьдчилан хянах; eBarimt, бараа материалын нэр төрлийн бүртгэл, авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг нэвтрүүлэх.
- **Ил тод байдал:** Мэдээлэл хариуцах ажилтныг тушаалаар томилж, шилэн данс, цахим хуудасны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах.

Зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгагдсан байгууллагын удирдлагатай 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хэлэлцсэн. Санал зөрөлдсөн асуудал гарвал талуудын албан ёсны тайлбарыг тайланд хавсаргана. Илрүүлэлтийн мөрөөр арга хэмжээ авах нь удирдлагын үүрэг хариуцлага мөн.

6.2. Хариуцах албан тушаалтанд өгөх зөвлөмж

Илрүүлэлт тус бүрийн шалгуурт заасан хууль тогтоомж, байгууллагын дүрэм, журамд үндэслэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хариуцах албан тушаалтанд зөвлөж байна.

Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд (үүсгэн байгуулагч, өмчлөгчийн төлөөлөл):

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг Хурлын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэхийг зөвлөж байна:

1. **Цалин хөлсний жишиг:** Хурлын 2026.06.29-ний 55 дугаар тогтоол гарахаас өмнө захирлын А/02 тушаалаар 20 дугаар тогтоолын хязгаарыг хэтрүүлэн 2026 оны 1–6 дугаар сард олгосон 171,818.2 мянган төгрөгийн цалин хөлсийг буцаан хүлээн зөвшөөрөх эсэх, эсхүл нөхөн төлүүлэх асуудлыг Хурлын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх; цаашид цалин хөлсний жишгийг төсвийн жил эхлэхээс өмнө, мөрдөж эхлэх хугацааг тодорхой заан батлах; 55 дугаар тогтоолоор баталсан 56 орон тоо, 2026 оны төлөвлөгөөний 60 ажилтны зөрүүг тодруулах. /3.2, 3.4, 3.7/
2. **Дүрэм, санхүүжилтийн загвар:** Дүрмийн 5.2.2-т “өөрийгөө бүрэн санхүүжүүлэх” зорилт тусгасан боловч 2026 оны 1–8 дугаар сард өөрийн орлого нийт орлогын 1.6 хувь, үлдсэн хэсэг нь төсвийн татаас байгааг харгалзан үйлдвэрийн газрын дүрэм, санхүүжилтийн хэлбэрийг бодит байдалд нийцүүлэн хянаж, шаардлагатай бол өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэх. /3.5/
3. **Тайлан хэлэлцэх, хяналт тавих:** ААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүүгийн жилийн тайлан, энэхүү аудитын үр дүнг Засаг даргын орон нутгийн өмчийн ажлын тайлангийн хамт Хурлын хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт, чиглэл өгөх; төлбөрийн акт (2,480.0 мянган төгрөг), албан шаардлага (557,420.6 мянган төгрөг)-ын хэрэгжилтэд хяналт тавих. /3.1–3.4, 3.6–3.8/

Сүхбаатар сумын Засаг даргад (үйлдвэрийн газрын даргыг томилох эрх бүхий албан тушаалтан):

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь заалтад заасан бүрэн эрхийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна:

1. **Удирдлагын хариуцлага:** Захирал ТБОНӨТХ-ийн 20.1.4-т заасан бүрэн эрхээ хэтрүүлж цалин, нэмэгдэл тогтоосон, хуулиар хориглосон зардал гаргасан, худалдан авах ажиллагааны хуулийг зөрчсөн асуудлыг захиралтай байгуулсан хөдөлмөрийн (үр дүнгийн) гэрээний биелэлтийг дүгнэхэд тусгаж, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлагын асуудлыг шийдвэрлэх. /3.1, 3.2, 3.4, 3.8/
2. **Цалингийн хязгаар:** Хурлын 2026.06.29-ний 55 дугаар тогтоолын 2 дахь заалтаар үүрэг болгосны дагуу ААТҮГ-ын 2026 оны үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд цалингийн сан, бүдүүвчийг жишигт нийцүүлэн тусгаж батлах; захирлын цалинг тогтоосон 2025.02.19-ний Б/07 захирамжийг 55 дугаар тогтоолд нийцүүлэн шинэчилж, ААТҮГ-ын ажилтан, албан хаагчдын цалинг

жишигт нийцүүлэн захирлын тушаалаар тогтоож олгож байгаа эсэхэд хяналт тавих. /3.2/

3. **Санхүүжилтийн хяналт:** Тамгын газраар дамжуулан олгох татаасыг ААТҮГ-ын гүйцэтгэлийн үр дүн, анхан шатны баримтын бүрдэл, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлттэй уялдуулан олгох; өөрийн орлогыг нэмэгдүүлэх хэмжигдэхүйц зорилтыг жилийн үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгуулж батлах. /3.3, 3.5/

4. **Тайлагнал, баримтын бүрдэл:** Аудитад ирүүлээгүй 2025 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, харилцах дансны хуулгыг бүрдүүлж хянуулах; ААТҮГ-ын жилийн тайланг Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр орон нутгийн өмчийн ажлын тайландаа тусгаж танилцуулах. /2.1, 3.10/

“Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын захирал Д.Цэлмэгт:

1. **Худалдан авах ажиллагаа:** ТОНӨХБАҮХАТХ-ийн 48.2.2, 50.1.1, 50.1.2-т нийцүүлэн үнэлгээний хороог зөв хууль зүйн үндэслэлтэй тушаалаар, хуульд заасан бүрэлдэхүүнтэй байгуулах; 51.8-д заасны дагуу үнэлгээний зөвлөмжийг гишүүн бүрээр баталгаажуулах, гишүүдээр ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл гаргуулах; 43.3-т заасны дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр, гэрээ байгуулахаас өмнө төлбөр хийхгүй байх, барааг хүлээлцэх актаар хүлээн авч байж төлбөрийг олгох; шаардлага хангахгүй гэж үнэлэгдсэн оролцогчтой байгуулсан давсны гэрээний гүйцэтгэлийг шалгаж дүгнэх. /3.1/
2. **Цалин хөлсний бүрэн эрх:** ТБОНӨТХ-ийн 20.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу цалин нэмэх шийдвэрийг сумын ИТХ цалин хөлсний жишгийг тогтоосны дараа, түүнд багтаан гаргах; 2026 оны А/02 тушаалыг ИТХ-ын 55 дугаар тогтоолын хавсралтад албан тушаал, орон тоо тус бүрээр нийцүүлэн өөрчилж, тогтоол батлагдсанаас хойш тушаалгүйгээр жишгээр бодож олгосон цалинг тушаалаар баталгаажуулах; ИТХ-ын жишгийг ажилтан тус бүрийн цалинд захирлын тушаалгүйгээр шууд хэрэглэхгүй байх; тогтоол гарахаас өмнө олгосон 171,818.2 мянган төгрөгийн асуудлыг өмчлөгчөөр шийдвэрлүүлэх. /3.2/
3. **Зардал батлах:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7-д нийцүүлэн зардал гаргах шийдвэр бүрийг анхан шатны баримтын бүрдэлтэй батлах; 19,112.0 мянган төгрөгийн зардлын баримтыг нөхөн бүдүүлүүлж, нотлогдоогүй дүнг нөхөн төлүүлэх; Төрийн хэмнэлтийн тухай хууль, Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар албан даалгаврын 5.4-т нийцүүлэн томилолт, арга хэмжээний зардлыг хэмнэх; /3.3/
4. **Нэмэгдэл тогтоох:** Хөдөлмөрийн дотоод журмын 7.7-д зааснаас давуулан 25 хувиар нэмэгдэл тогтоосон 2026 оны Б/01, Б/02 тушаалыг журамд нийцүүлэн өөрчилж, 1,229.3 мянган төгрөгийг төлбөрийн актын дагуу нөхөн төлүүлэх; ХДЖ-ийн 7.1-д заасны дагуу нэмэгдлийг зөвхөн захирлын тушаалаар тогтоож, тушаалгүйгээр олгосон 1,076.3 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх. /3.4, 3.7/
5. **Өөрийн орлого:** Дүрмийн 5.2.1, 5.2.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор үйлчилгээний төлбөр, хураамжийн тариф, гэрээт ажлын орлогын хэмжигдэхүйц зорилт бүхий төлөвлөгөөг ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлд заасан эрх

хэмжээний хүрээнд өмчлөгчөөр батлуулах; бодит санхүүжилтийн загвар дүрэмтэй нийцэхгүй бол дүрэмд өөрчлөлт оруулах саналыг өмчлөгчид хүргүүлэх. /3.5/

6. **Хориглосон зардал:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.7-д заасны дагуу байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахгүй байх, 174.4 мянган төгрөгийг төлбөрийн актын дагуу нөхөн төлөх. /3.8/
7. **Ил тод байдал:** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3–8.6, Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1, 3.2-т заасан мэдээллийг байршуулах хариуцлагатай албан тушаалтныг тушаалаар томилж, хуваарь батлан хяналт тавих. /3.10/
8. **Сахилгын шийтгэл:** Шийтгэлийн шийдвэрт Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.3-т заасан “үндсэн цалинг бууруулах” хэлбэр, хувь, хугацааг тодорхой тусгаж, суутгалыг зөвхөн үндсэн цалингаас тооцуулах. /3.11/
9. **Дотоод хяналт:** Захирлын тушаал, зардлын шийдвэрийн төслийг гаргахаас өмнө нягтлан бодогчоор хууль тогтоомж, дотоод журам, төсөвтэй тулгаж хянуулдаг журам баталж мөрдөх. /3.2–3.4, 3.7, 3.8/

“Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч Ц.Ариунзулд:

1. **Урьдчилсан хяналт:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасны дагуу ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулж, хуулиар хориглосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг хийхгүй байх. /3.3, 3.7, 3.8/
2. **Баримт нөхөн бүрдүүлэх:** 19,112.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7-д нийцүүлэн нөхөн бүрдүүлж, нотлогдоогүй дүнг холбогдох этгээдийн авлагад бүртгэх. /3.3/
3. **Бараа материалын бүртгэл:** Татварын ерөнхий хуулийн 29.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д нийцүүлэн 39,303.2 мянган төгрөгийн 37 баримтыг задаргаатай баримтаар нөхөн бүрдүүлж, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд нэр төрөл, тоо хэмжээгээр залруулан бүртгэх. /3.6/
4. **Цалин бодолт:** Цалинг сар бүр захирлын тушаал, ХДЖ-ийн 7.1, 7.7-д заасан хувь хэмжээтэй ажилтан тус бүрээр тулгаж бодох; программд нэмэгдлийн хувийг зөвхөн тушаалд үндэслэн өөрчлөх. /3.4, 3.7/
5. **Сахилгын суутгал:** Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.3-ын дагуу суутгалыг үндсэн цалингаас дахин тооцож, нэмэгдлээс буруу суутгасан дүнг ажилтан тус бүрээр залруулах. /3.11/
6. **Хураамжийн орлого, авлага:** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7.2.6, 8.1.1-д нийцүүлэн хог хаягдлын үйлчилгээний орлого бүрд цахим төлбөрийн баримт үүсгэж, авлагыг өрх, байгууллага тус бүрээр хөтөлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-ын дагуу улирал бүр тооцоо нийлэх. /3.9/
7. Актын тооцоо: Төлбөрийн актаар нөхөн төлүүлэ х 2,480.0 мянган төгрөгийг (1,229.3; 1,076.3; 174.4 мянган төгрөг) авлагад бүртгэж, төлөгдсөн дүнг баримтаар баталгаажуулан СХДАГ-т тайлагнах. /3.4, 3.7, 3.8/

8. **Шилэн данс:** Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4-т заасан хугацаанд байршуулах. /3.10/

6.3. Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 10. Илрүүлэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Эрэмбэ	Арга хэмжээ	Хариуцагч	Хугацаа	Удирдлагын байр суурь	Хэрэгжилтийн төлөв
1 (ӨНДӨР)	327,187.2 мянган төгрөгийн 3 тендерийн баримт бичгийг хуульд нийцүүлж, үнэлгээний хороог хуулийн 50.1-д заасан бүрэлдэхүүнтэй байгуулах, гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг бүрдүүлж, гэрээ байгуулахаас өмнө төлбөр хийхгүй байх.	Захирал Д.Цэлмэг	Албан шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
2 (ӨНДӨР)	А/02 тушаалыг сумын ИТХ-ын 2026.06.29-ний 55 дугаар тогтоолын хавсралтад албан тушаал, орон тоо тус бүрээр нийцүүлэн өөрчилж, тогтоол батлагдсанаас хойш тушаалгүйгээр жишгээр бодож олгосон цалинг захирлын тушаалаар баталгаажуулах; 2026 оны цалингийн сан, бүдүүвчийг үйлдвэрлэл, санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгуулан Засаг даргаар батлуулах; тогтоол гарахаас өмнө олгосон 171,818.2 мянган төгрөгийн асуудлыг өмчлөгчөөр (сумын ИТХ) хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.	Захирал Д.Цэлмэг	2026.12.31	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
3 (ӨНДӨР)	19,112.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг (гэрээ, нэхэмжлэх, гүйцэтгэлийн акт, томилолтын удирдамж, тайлан, төлбөрийн баримт) нөхөн бүрдүүлж, баримтаар нотлогдоогүй дүнг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх.	Захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул	Албан шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
4 (ДУНД)	1,229.3 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Б/01, Б/02 тушаалыг ХДЖ-д нийцүүлэн өөрчлөх.	Захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул	Акт гардуулснаас хойш 30 хоног	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
5 (ДУНД)	1,076.3 мянган төгрөгийг холбогдох ажилтан, албан тушаалтнаар нөхөн төлүүлж, нэмэгдлийг зөвхөн захирлын тушаалаар тогтоож олгох.	Захирал Д.Цэлмэг, нягтлан бодогч Ц.Ариунзул	Акт гардуулснаас хойш 30 хоног	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
6 (ДУНД)	Сахилгын шийтгэлийг үндсэн цалингаас тооцож, буруу суутгасан дүнг залруулах.	Нягтлан бодогч Ц.Ариунзул	2026.12.31	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
7 (ДУНД)	Өөрийн орлогыг нэмэгдүүлэх (гэрээт хог тээвэр, тохижилт, техник түрээс) төлөвлөгөө боловсруулж, үйлдвэрлэл, санхүүжилтийн жилийн төлөвлөгөөнд хэмжигдэхүйц зорилт тусгаж, өмчлөгчөөр батлуулах.	Захирал Д.Цэлмэг	2027 оны 1 дүгээр улирал	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй

Эрэмбэ	Арга хэмжээ	Хариуцагч	Хугацаа	Удирдлагын байр суурь	Хэрэгжилтийн төлөв
8 (ДУНД)	39,303.2 мянган төгрөгийн 37 баримтыг нийлүүлэгчээс нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн задаргаатай баримт (eBarimt, нэхэмжлэх, зарлагын баримт)-аар нөхөн бүрдүүлж, бараа материалыг нэр төрөл, тоо хэмжээгээр нь залруулан бүртгэх.	Нягтлан бодогч Ц.Ариунзул	Албан шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
9 (ДУНД)	Хураамж, төлбөр бүрд eBarimt үүсгэж, айл өрх, байгууллагаар авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, улирал бүр тооцоо нийлэх.	Нягтлан бодогч Ц.Ариунзул	2026.12.31	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
10 (ДУНД)	Мэдээлэл хариуцах ажилтныг тушаалаар томилж, хуулийн хугацаанд мэдээллийг байршуулж, улирал бүр хяналт тавих.	Мэдээлэл хариуцсан ажилтан	2026.12.31, цаашид улирал бүр	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй
11 (БАГА)	174.4 мянган төгрөгийг шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх.	Захирал Д.Цэлмэг	Акт гардуулснаас хойш 30 хоног	Зөвшөөрөв	Хугацаа болоогүй

6.4. Хэрэгжилтийн эргэн хяналт (Стандарт 15.2)

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг шийдвэрийн хэрэгжилтийн бүртгэлд (зөвлөмж, албан шаардлага, акт тус бүрээр) тусгаж, хугацаа дуусахаас өмнө удирдлагаас хэрэгжилтийн тайлан, нотлох баримт авна. Өндөр түвшний илрүүлэлтэд баримтаар болон газар дээр нь эргэн хяналтын үнэлгээ хийж, дунд, бага түвшнийхийг удирдлагын тайлан, нотлох баримтаар баталгаажуулна. Тогтоосон хугацаанд ахиц гараагүй бол удирдлагаас тайлбар авч баримтжуулан, газрын даргатай хэлэлцэж, хүлээн зөвшөөрөгдөх түвшнээс давсан эрсдэлийг өмчлөгчид мэдээлнэ. Хэрэгжилтийн төлөвийг “Хэрэгжсэн”, “Хэсэгчлэн”, “Хэрэгжээгүй”, “Хугацаа болоогүй” гэсэн 4 ангиллаар бүртгэнэ; тайлан гарсан өдрийн байдлаар бүх арга хэмжээ “Хугацаа болоогүй” төлөвтэй байна.

6.5. Стандартад нийцсэн тухай мэдэгдэл

Энэхүү баталгаажуулах аудитын ажлыг Дотоод аудитын Дэлхийн Стандарт (ДАДС, 2024)-д нийцүүлэн гүйцэтгэв. Аудитын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, баримтжуулалт, тайланг газрын дарга хянаж баталсан бөгөөд дотоод аудитын нэгжийн чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөрөөр дэмжигдэж байна. Стандартаас зөрсөн, эсвэл илрүүлэлт, дүгнэлтэд нөлөөлөх үл нийцэл гараагүй болно.

6.6. Түгээлтийн жагсаалт

Хүлээн авагч	Зориулалт
Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (үүсгэн байгуулагч)	Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах
Сүхбаатар сумын Засаг дарга (даргыг томилох эрх бүхий албан тушаалтан)	Зөвлөмж хэрэгжүүлэх, хяналт тавих
“Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын захирал	Хэрэгжүүлэх

Хүлээн авагч	Зориулалт
Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар	Санхүүжилт, хяналт
Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	Архив, эргэн хяналт

Бэлтгэсэн: Дотоод аудитор . /Х.Батбаатар/

Хянаж, баталсан: СХДАГ-ын дарга /Т.Одсүрэн/

Танилцсан: ААТҮГ-ын захирал /Д.Цэлмэг/

Танилцсан: Нягтлан бодогч /Ц.Ариунзул/